

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл 2020 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр 2020-2024”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийг 2020-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг боловсруулж, энэ оны 01/482 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07, А/08 А/24 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2020 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г тус тус баталж, хэрэгжилтийг хангаж, биелэлтийг эхний хагас жилийн байдлаар 90.7, 91.0, 92.0 хувьтай тооцож ажилласан.

Салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нийт 37 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг анги, байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах, засаж залруулах ажлын хүрээнд холбогдох алба, нэгж, байгууллагаас саналыг авч нэгтгэн, 156 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулсан. Үүнээс Экологийн цагдаагийн албаны 27, Хар тамхитай тэмцэх газрын 25, бусад албан тушаалын 15 нийт 67 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, албан тушаалын нэршил өөрчилсөн 15, нэмэлт, өөрчлөлт оруулсан 74 албан тушаалын тодорхойлолт байна. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон албан тушаалын тодорхойлолтыг цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн алба хаагчдад зориулсан гарын авлага хэсэг //http://guide.police.gov/-т байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангасан.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 бүлэг, 28 арга хэмжээтэйгээр

төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилд төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжсэн.

Тус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргаж 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/01 тоот албан бичгээр, байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүний хөдөлгөөний тайлангийн хамт хүргүүлсэн.

Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр www.police.gov.mn цахим хуудаст байршуулж мэдээлсэн.

Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, түүний хэрэгжилтийг тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

Тайлангийн хугацаанд тус салбар зөвлөл нийт 8 удаа хуралдаж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дэвшүүлэх албан тушаалын нөөцөд бүртгэх тухай, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд иргэдээс сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай, нөөцөд бүртгэх тухай, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийг 81 төгсөгчийг томилох тухай, шагналд нэр дэвшүүлэх тухай асуудлуудыг тус тус хэлэлцэж баталсан.

Хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төсөл 8 боловсруулж батлуулсан.

Дөрөв. Салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхэд хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал үр дүн

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд үйл ажиллагаанд холбогдох бодлогын 24, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 74, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 6 баримт бичиг, захиргааны хэм хэмжээний акт 10, Монгол Улсын Ерөнхийлөгч, Төрийн албаны зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн зарлиг, тушаал, зөвлөмж, албан даалгавар, үүрэг, тушаал шийдвэр, үүрэг, даалгавар нийт 145 баримт бичгийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг холбогдох дээд шатны байгууллагад тайлагнахаас энэ оны эхний хагас жилд 74 баримт бичгийн 122 ажил, арга хэмжээ, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, үр дүнг тооцон, хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 51 гомдол, санал, 8 нууцын зэрэглэлтэй албан бичгийн эрх зүйн зохицуулалтыг судалж, дүгнэлт гарган, хууль зүйн зөвлөгөө өгсөн ба цагдаагийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах гэрээ 13, ажил гүйцэтгүүлэх болон бусад гэрээ, гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, хэлэлцээрийн 22 төслийг хянаж, шинээр батлагдсан 19 хууль тогтоомж, эрх зүйн актыг холбогдох алба, нэгжид хүргүүлж, мэдээллээр хангасан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой 71 эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон

хамтран баталсан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, алба хаагчийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судлах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөмж өгөх, мэдээллээр хангах зорилгоор цагдаагийн байгууллагын “Мэдээлэл танилцуулгын систем” /info.police.gov/ цахим хуудсанд “Helpline” буюу “Танд тусалъя” цэсийг шинээр бүтээж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллагаас халагдсан, чөлөөлөгдсөн, данс бүртгэлээс хасагдсан алба хаагчдын хувийн хэргийг хадгаламжийн нэгж болгон Төв архивд шилжүүлэх чиглэлээр ажлын хэсгийг байгуулан, нийт 1063 хувийн хэргийг хадгаламжийн нэгж болгосноос 785 хувийн хэргийг архивд шилжүүлэн өгч, 273 хувийн хэргийг Хүний нөөцийн хэлтсийн хувийн хэргийн санд хадгалж, албан тушаалд томилогдсон 5 алба хаагчийн хувийн хэргийг харьяалах алба, нэгжид хүргүүлсэн.

Тав. Салбарын хэмжээнд хууль, журам, заавар төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаартай зөвлөмж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1и/681 дугаартай албан бичгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төсвийн төлөвлөлтөд”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээний хэрэгжилтэд”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаанд”, “Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн үйл ажиллагаанд”, “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.8 дахь хэсгийн хэрэгжилтэд”, “Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтанд нөхөх олговор, тусламж, дэмжлэг, эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн үйл ажиллагаанд”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Шилэн дансны хэрэгжилтийн байдалд” 2 удаа, нийт 8 удаагийн дотоод аудитын тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 6 төрлийн 36 заалт бүхий санал, зөвлөмжийг холбогдох 53 нэгжид хүргүүлсэн.

Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын чиглэлээр харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийт 419 алба хаагчид 16 удаагийн 30 цагийн сургалт, дадлагыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Зургаа. Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07, А/08 А/24 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2020 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг,

ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-г тус тус баталж, энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 2344 удаагийн 3482 цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 305738, мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн 4608 төрлийн ажил, арга хэмжээг мэдээлэл технологийн өргөн боломжийг ашиглан зайн болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 736225 алба хаагчийг тус тус хамруулан үр дүнг тооцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмуудыг алба хаагчдад судлуулах, зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 183 удаагийн сургалтад 10644, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 28 удаагийн сургалтад 12004, Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр 40 удаагийн сургалтад 29813, Дотоодын цэргийн үйл ажиллагаа, улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 32 удаагийн сургалтад 24165, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын чиглэлээр 45 удаагийн сургалтад 6546 алба хаагч тус тус давхардсан тоогоор хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн төр, захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран 35 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 781 алба хаагч, 21248 иргэнийг хамруулсан байна.

Алба хаагчдын сургалтад зориулж 496 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 351 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 5412 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 22.8 сая төгрөг зарцуулсан.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 45 удаагийн зайн болон цахим сургалтад 13913 алба хаагчийг хамруулж, сургалтын багц кредит цаг хангуулан, гэрчилгээ олгож, иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтын хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх 2 удаагийн сургалтад 97, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны 6 удаагийн сургалтад 199 иргэнийг хамруулж, гэрчилгээ олгосон.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ хөтөлбөрийн сургалтад 386, магистрын хөтөлбөрийн сургалтад 53, докторын хөтөлбөрийн сургалтад 15, Удирдлагын сургуульд 28, нийт 482 алба хаагчийг суралцуулж байна.

Мөн алба хаагчдын мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Турк Улс, Тайвань, Бүгд Найрамдах Унгар, Австрали зэрэг 6 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 95, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Турк, Бүгд Найрамдах Казахстан Улс, Катар, Япон зэрэг 5 улсад богино хугацааны 6 удаагийн сургалтад 19, нийт 114 алба хаагчийг суралцуулсан.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан тушаал, түүнд тавигдах тусгай шаардлагыг хэрэгжүүлэх ажлын

хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуультай хамтран Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалын 183 алба хаагчийг “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх зайн сургалт”-д, “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалт”-д 1 алба хаагчийг тус тус хамруулсан.

Долоо. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаа, дотоодын цэргийн 32 анги, байгууллага төв, орон нутгийн Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагч, ажилтныг гэр бүлийн хамт ханиад, томуугаас урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, цагдаа, дотоодын цэргийн 50 анги, байгууллага нийт 203.286.000 төгрөгийн нэг удаагийн хувийн хамгаалах хэрэгсэл худалдан авч, бэлэн байдлыг хангаж ажилласан.

Байгууллагын хэмжээнд халдвар хамгааллын хувцас /нэг удаагийн комбинзон/ 11.968, Нүдний шил 5.223, нүүрний хаалт 4.000, нэг удаагийн амны хаалт 7.250, даавуун амны хаалт 31.500, N95 стандартын амны хаалт 10.676, нэг удаагийн малгай 14.250, улавч 14.550, бээлий 21.650, гар ариутгагч /1 литр савалгаатай/ 1.700, /300 гр савалгаатай/ 1.900, /санитол 100 миллилитр/ 72, спирт /денутрат/ 3.1 тонн, зайнаас биеийн халуун хэмжигч 10, ариутгалын бодис /жавелион/ 200 хайрцаг, ариутгалын шүршигч /автомакс/ 31 ширхгийг нийт 278.976.700 төгрөгийн бараа материалыг “Хөдөлмөр хамгааллын зардал”-аас худалдан авч, нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангасан.

Бүрдүүлсэн нөөцөөс цагдаа, дотоодын цэргийн 74 анги, байгууллагад халдвар хамгааллын хувцас 11.915, Нүдний шил 3.449, нүүрний хаалт 1.901, нэг удаагийн амны хаалт 24.350, даавуун амны хаалт 31.218, N95 стандартын амны хаалт 30.672, нэг удаагийн малгай 9.655, улавч 11.445, бээлий 51.933, гар ариутгагч /1 литрийн савалгаатай/ 1.357, /300 миллилитрийн савалгаатай/ 922, спирт /денутрат/ 2.575 литр, зайнаас биеийн халуун хэмжигч 10, ариутгалын бодис /жавелион/ 204, шүршигч /автомакс/ 270, гарын авлага 2.050 ширхгийг тус тус олгоод байна.

Цагдаа, дотоодын цэргийн 62 анги, байгууллага “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс”, осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг томилуулж, аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалаа.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дүгээр тушаалын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажилладаг бохирын үйлчлэгч нарт үндсэн цалингийн 20 хувиар бохирын нэмэгдлийг сар бүр, Хөдөлмөрийн хүнд хортой нөхцөл буюу гудамж, замд үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдад хор саармагжуулах бүтээгдэхүүний мөнгө хоногт 900 төгрөгийг ажилласан хоногоор тооцон тогтмол нэмж олгосон. Мөн эрүүлжүүлэх байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг 2020 онд

хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 95.8 хувьтай дүгнэгдсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлыг төлөвлөн, даатгуулах алба хаагч, автомашин, тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн судалгааг гаргаж, гэнэтийн ослын даатгалд 6.904 албан хаагч, үл хөдлөх хөрөнгийн даатгалд 777 барилга, байгууламж, тээврийн хэрэгслийг даатгалд 884 автомашиныг бүрэн хамрууллаа.

Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2019 оны жилийн эцсийн байдлаар алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэн, албан тушаал дэвшүүлэх алба хаагчийн нөөцийн санд бүртгүүлэхээр ирүүлсэн санал, материалыг хууль тогтоомж, журамд заасны дагуу ажилласан жил, ажлын туршлага, ур чадвар, гүйцэтгэлийн тайлан, үр дүнгийн үнэлгээгээр эрэмбэлж, сахилгын шийтгэл, гэмт хэрэг, зөрчлийн холбогдлыг зохих эрх бүхий байгууллагаар шалгуулан, эрүү, мөрдөн, хэрэг бүртгэх, нийтийн хэв журам хамгаалах, тээвэр, захиргаа, санхүү аж ахуй, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны, хэлтэс, газар, албаны даргын, дотоодын цэргийн гэсэн чиглэлээр төрөлжүүлж, офицерын бүрэлдэхүүнд, ахлахын, чиглэлийн ахлахын, тасаг, хэсгийн даргын, хэлтэс, газар, албаны даргын гэсэн бүтэцтэйгээр жагсаалтыг гарган, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталгаажуулж, офицер албан тушаалын нөөцөд 539, ахлах албан тушаалын нөөцөд 564 /НЦУГ-ын ахлах албан тушаалын нөөцөд 18/, чиглэлийн ахлах албан тушаалын нөөцөд 41, хэсэг, тасгийн дарга албан тушаалын нөөцөд 222 /НЦУГ-ын тасгийн дарга албан тушаалын нөөцөд 36/, хэлтсийн дарга албан тушаалын нөөцөд 89, газрын дарга албан тушаалын нөөцөд 27, албаны дарга албан тушаалын нөөцөд 13, нийт 1495 алба хаагчийг бүртгэж, Цагдаагийн байгууллагын system.police.gov.mn дотоод сүлжээний гарын авлага хэсэгт байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангалаа. Удирдах ажилтны нөөцөд бүртгэгдсэн алба хаагчдаас газар, хэлтсийн даргаар 16 алба хаагчийг эхний хагас жилийн байдлаар дэвшүүлэн томилоод байна.

Ес. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хүн, хүчний хэрэгцээ шаардлагын улмаас Төрийн албаны зөвлөлд албан бичиг хүргүүлэн “Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл”-ийг авч, нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Төрийн албаны тусгай шалгалт өгч цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд ажиллах хүсэлтэй эсэхийг иргэдтэй холбогдон тодруулахад цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан иргэн байхгүй байсан учраас Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн

сургуультай хамтран хэв журмын цагдаа, цагдаа-жолооч, эм зүйч, химич, биологич, экологийн мэргэжилтэн, Дотоодын цэргийн байгууллагад жолооч, эргүүл, харуулчны ажлын байранд бакалаврын болон бүрэн дунд боловсролтой хугацаат цэргийн алба хаасан, иргэдийг шалгаруулан суралцуулах ажлыг зохион байгуулах зар, зарлаж буй 329 албан тушаал /ажлын байр/ тус бүрд тавигдах мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага болон бусад тусгай шаардлага зэргийг бэлтгэн 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр харьяа, алба, нэгж, байгууллагад хүргүүлж, байгууллагын цахим хуудас /[www. police.gov.mn](http://www.police.gov.mn)/, Хэвлэл мэдээллийн төвийн facebook хаяг, орон нутгийн цагдаагийн байгууллагын цахим хаягуудад байршуулан иргэдэд мэдээлж, бүртгэлийг явуулсан.

Элсэлтийн шалгалтын зарыг “Өдрийн сонин”-ы 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №010/6378/ дугаарын 8-р нүүрэнд нийтлүүлж, 51 секундийн шторк хийлгэн ажил хариуцсан алба хаагчийн “Ахлагчийн сургуульд элсэн суралцаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллахыг урьж байна” сэдэвт ярилцлагыг Хэвлэл, мэдээллийн төвд хүргүүлж, www.police.gov.mn сайтад байршуулан, 2020 оны 01 дүгээр сарын 56/277 дугаартай ажлын чиглэлийг нэгжүүдэд хүргүүлэв. Шторкийг 73.415 удаа үзэж, 596 хүнд таалагдаж, 214 сэтгэгдэл үлдээж, 943 удаа хуваалцсан бол ярилцлагыг 30.110 хүн үзэж, 135 хүнд таалагдаж, 30 сэтгэгдэл үлдээж, 412 удаа хуваалцсан байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, шинэ коронавирусын дэгдэлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн элсэлтийн шалгалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний мэдээллийг 2020 оны 3/93, 56/1394 дугаартай албан бичгүүдээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, улмаар бүртгэл, шалгалтыг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган 2020 оны 04 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Бүртгүүлсэн 506 иргэнээс шалгалтыг цахимаар авч, тэнцсэн 418 иргэний мэдээллийг Цагдаагийн байгууллагын цахим хуудас [www. Police.gov.mn](http://www.Police.gov.mn) веб сайтын нүүр хуудаст байршуулж ажилласан.

Хар тамхитай тэмцэх газрын тусгай мэргэжлийн хүний нөөцийг болон Экологийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор албан тушаалын тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тоот тушаалаар батлагдсан тусгай мэргэжил, мэргэшил шаардах албан тушаалын шалгалтын хуваарь, төлөвлөгөө, Дэд даргын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн мэдээлэл, ажлын чиглэлийн дагуу Мөрдөн байцаах болон Хэрэг бүртгэх албаны хурлын танхимд 2020 оны 04 дүгээр сарын 10, 13-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

Шинээр үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх чиглэлээр Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газрын харьяа цэргийн ангиудад алба хааж буй хугацаат цэргийн алба хаагч нартай уулзаж, судалгаа хийх, бүртгэлд авах, сургалт явуулах, цаашид албанд авч ажиллуулах чиглэлээр санал, танилцуулга бэлтгэн, Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарт хамтран ажиллах тухай 2020 оны 03 дугаар сарын 18-

ны өдрийн 01/217 дугаартай албан бичгийг хүргүүлснээр Зэвсэгт хүчний жанжин штабаас цагдаагийн байгууллагад ажиллах саналтай 223 иргэний судалгааг ирүүлсэн. Дээрх иргэдийг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаар эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгуулж, гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 16 иргэнийг бүртгэлээс хассан. Бусад иргэдийн гэрийн хаягийн судалгааг гарган, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад албан бичгээр хүргүүлж, бүртгэлд авах, судлах, материал бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хүн, хүчний хэрэгцээ шаардлагыг харгалзан Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг энэ оны 07 дугаар сарын 01-нээс 03-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөж, бүртгэлийг 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлүүлж, мэдээлэл, ажлын чиглэлийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 5б/3949, 06 дугаар сарын 29-ний 5б/4585 дугаартай албан бичгүүдээр харьяа, алба нэгж байгууллагад хүргүүлэв. Элсэлтийн шалгалтын талаарх тус хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ж.Баясгалангийн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэдийг бүртгэж байна” сэдэвт ярилцлагыг Хэвлэл, мэдээллийн төвд хүргүүлж, байгууллагын www.police.gov.mn цахим сайт, фэйсбүүк хаягт байршуулав.

Арав. Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмын дагуу нөөц бүрдүүлэх, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмын 3-д заасны дагуу “Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөц”-д 1495, “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц”-д 26, “Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээд офицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц”-д 286 иргэн тус тус бүртгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд нөөцөд бүртгэгдсэн 808 иргэнийг албан тушаалд томилсноос 639 иргэнийг цагдаагийн бага цолны албан тушаалд, 169 алба хаагчийг офицерын албан тушаалд тус тус томилсон.

Арван нэг. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт

Төрийн албаны зөвлөлөөс Г.Эрдэнэчимэг, Г.Баасанжав, Ж.Мөнхтогоо, Х.Хурметбек, М.Саруул-Эрдэнэ, Г.Төгсбаяр, Ч.Буян-Өлзий, Ч.Анхбаяр, Д.Батбаяр нарыг албанаас хууль бусаар халсан тухай гомдолд тайлбар авах 8 албан бичгийг салбар зөвлөлд ирүүлснээр холбогдох тайлбарыг бэлтгэн, бичиг баримтын хамт хүргүүлсэн. Хүргүүлсэн тайлбарын дагуу 6 алба хаагчийн талаар гаргасан Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн тул шийдвэрийг хувийн хэрэгт баяжилтаар хийж, 3 алба хаагчийн шийдвэр Төрийн албаны зөвлөлд хянагдаж байна.

Б.Мөнхбатыг халсан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/934 дүгээр тушаалыг хүчингүй болгох тухай албан бичгийг хүлээн авч, Б.Мөнхбатыг

Эргүүл, хамгаалалтын газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн тасгийн даргаар томилж хариуг хүргүүлэв.

Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн дагуу Цагдаагийн байгууллагад хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Хүний нөөцийн аудитын үзэл баримтлал журам, хүний нөөцийн аудиторын баримтлах ёс зүйн дүрмийн төсөлтэй танилцаж, төсөлд санал өгөх тухай албан бичгийн дагуу Хүний нөөцийн аудитын журамд 8, Хүний нөөцийн аудиторын ёс зүйн дүрэмд 5 саналыг тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

ДҮГНЭЛТ:

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл нь 2020 оны эхний хагас жилд төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлсэн гэж дүгнэж байна. Тухайлбал :

- Салбар зөвлөлийн ажлын төлөвлөлт, тайлагналт, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалт, шийдвэрийн албажуулалт, түүний хэрэгжилтэд тавих хяналт, албан хэрэг хөтлөлтийн стандарт, архивын бүрдүүлэлт буюу зөвлөлийн дотоод ажил шаардлагын түвшинд хүрсэн.

- Төрийн албаны шинэтгэл, байгууллагын хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулахад мэргэшлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх ажилд тодорхой ахиц гарлаа.

- Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах ажлыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, баяжилтыг хийж, энэ талаар ямар нэг зөрчилгүй ажилласан.

- Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн, хугацаатай албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд нь хүргүүлж ажиллаа.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**